



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/28/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он

| | |
|--------------------|-----------------------------------------|
| Тэргүүлэх аудитор: | Ч.Ариунаа |
| Утас: 70522734 | Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn |
| Аудитын менежер: | Э.Энхцэцэг |
| Утас: 70523020 | Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn. |
| Аудитор: | Г.Энхтөр |
| Утас: 99032916 | Цахим хаяг: ij17.audit@gmail.com |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | | |
|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан..... | 5 |
| 2.1. | Оршил..... | 5 |
| 2.2. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 6 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 7 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 7 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 8 |
| 2.8. | Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 8 |
| 2.9. | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 9 |
| 2.10. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 10 |
| 2.11. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 10 |
| 2.12. | Шилэн дансны мэдээлэл | 10 |
| 2.13. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 10 |
| 2.14. | Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 10 |
| 3 | Менежментийн захидал..... | 11 |
| 4 | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан | 14 |

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/278

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД
СУМЫН ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.СҮГЛЭГМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


2019 оны сүүлийн хагас жилийн тооллого хийхээр цэцэрлэгийн эрхлэгч 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр А/32 тоот тушаал гарган тооллого хийсэн байна. Гэвч тооллогын бүртгэл /НХМаягт БМ-8/-г нягтлан бодогч бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдэлтэй тулган шалгаагүйн улмаас 24,186.48 мянган төгрөгийн бараа материалд тооллого хийгдээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байхаас гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа", 71 дүгээр зүйл "Эд хөрөнгийн тооллогын бэлтгэлийг хангах", 72 дугаар зүйл "Тооллогын комисс, түүний эрх, үүрэг", 73 дугаар зүйл "Эд хөрөнгийн тооллого явуулах журам" -ыг тус тус зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Ц.Сүглэгмаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 7-ноос 2020 оны 2 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь "Эелдэг, найрсаг харилцааг эрхэмлэх, хүүхэд нэг бүрийн онцлог, хөгжлийн түвшин, хэрэгцээ сонирхолд нийцүүлэн ажиллах, хүүхэд бүрийн тэгш оролцоог хангах, хүүхдийн онцлог давуу тал дээр тулгуурлан хөгжүүлэх, хүүхдийн бие даасан бүтээлч чадварыг хөгжүүлэх, хүүхдийн өөрийгөө илэрхийлэх чадварыг дэмжих, хүүхдэд хайр халамжийг мэдрүүлж багш, ажилтан, эцэг эхтэй хамтран сурч хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 36 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж байгаа тул нийт зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны нийт зардал 447,204.15 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 894.41 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,010.25 мянган төгрөгөөр буюу 9.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|-------------------------------------|-------------------|-------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 1,419.57 | 0 | -1,419.57 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 44,567.66 | 49,742.13 | 5,174.47 |
| Үндсэн хөрөнгө | 777,180.67 | 855,436.02 | 78,255.35 |
| Нийт хөрөнгө | 823,167.89 | 905,178.14 | 82,010.25 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 823,167.79 | 905,177.72 | 82,009.93 |
| Нийт өр төлбөр ба цэвэр | 823,167.89 | 905,178.14 | 82,010.25 |

| | | | |
|---------------------------|--|--|--|
| хөрөнгө өмчийн дүн | | | |
|---------------------------|--|--|--|

Бараа материалын дансны үлдэгдэлд аж ахуй материалын үлдэгдэл нийт бараа материалын 70 орчим хувийг эзэлж байна. Тухайн аж ахуй материалуудыг ашиглалтаас хасагдах хүртэл буюу актлах үедээ л шаардахаар зарлагаддаг. Энэ нь тухайн дансны үлдэгдлийг өндөр харагдуулж байна. Хэрэв тухайн бараа материалыг шаардахаар тавьж олгоод зарлагадаад явбал тухайн материалыг байгууллагад бүртгэлгүй гээд ариг гамтай ашиглах байдал буурна гэж үзэн бараа материалаа ашиглах боломжгүй болтол нь хөрөнгөндөө бүртгэлтэйгээр байлгадаг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн шалтгаан нь 2020 оны 1 дүгээр сард хэрэглэхээр 2019 оны 12 дугаар сард 4,488,50 мянган төгрөгийн үнэ бүхий мах худалдан авсантай шууд холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь УТХО-аар цэцэрлэгийн барилгын гадаад болон дотор шугамын бүрэн засвар хийсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгө өссөн байна. 2019 онд хөрөнгө оруулалтаар 87,579.50 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 11,458.00 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгөнөөс 10,615.60 төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 905,177,7 мянган төгрөг болж 82,009.90 мянган төгрөгөөр өссөн нь УТХО засварын ажил хийж өөрийн хөрөнгийг өсгөх гол шалтгаан болсон байна. Энэ нь байгууллагын нийт хөрөнгийг нэмэгдүүлж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, өмнөх тайлант хугацаанд хамаарах алдааны залруулга хийгдээгүй.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 429,961.60 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зардлын 315,116.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 114,894.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 424,924.77 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсөв байхгүй.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 24,201.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн 24,201.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгасан бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах бусад чухал асуудал гараагүй

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1 дүгээр цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” санал дүгнэлт

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2019 оны сүүлийн хагас жилийн тооллого хийхээр Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/32 тоот тушаал гарган тооллого хийсэн байна. Гэвч тооллогын бүртгэл /НХМаягт БМ-8/-г нягтлан бодогч бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдэлтэй тулган шалгаагүйн улмаас 24,186.48 мянган төгрөгийн бараа материалд тооллого хийгдээгүй байна.
2. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан үндсэн хөрөнгөтэй холбоотой анхан шатны маягтуудыг үндэслээгүй, бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-н маягтаар тайлагнасан байна.
3. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан зааврын дагуу үнэн зөв хөтөлдөггүй байна.
4. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар НДШ-ийн авлага 15.2 мянган төгрөг байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2019 оны сүүлийн хагас жилийн тооллого хийхээр Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/32 тоот тушаал гарган тооллого хийсэн байна. Гэвч тооллогын бүртгэл /НХМаягт БМ-8/-г нягтлан бодогч бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдэлтэй тулган шалгаагүйн улмаас 24,186.48 мянган төгрөгийн бараа материалд тооллого хийгдээгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль зөрчигдөх, бараа материалын илүүдэл, дутагдал гарах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа”, 71 дүгээр зүйл “Эд хөрөнгийн тооллогын бэлтгэлийг хангах”, 72 дугаар зүйл “Тооллогын комисс, түүний эрх, үүрэг”, 73 дугаар зүйл “Эд хөрөнгийн тооллого явуулах журам” заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан үндсэн хөрөнгөтэй холбоотой анхан шатны маягтуудыг үндэслээгүй, бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-н маягтаар тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг хөтөлбөл зохих анхан шатны баримтгүйгээр тайлагнах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодогч Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар баталсан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл /ҮХ-1/-г хөтлөхдөө Сангийн сайдын 2017 оны 347 тоот

тушаалаар баталсан анхан шатны баримт болох ҮХ-1, ҮХ-2, ҮХ-3, ҮХ-4 маягтуудыг үндэслэх бөгөөд дээрх бүртгэл, маягтуудыг холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална. Иймд Сангийн сайдын баталсан дээрх заавар маягтуудыг судлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.3 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.3.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан зааврын дагуу үнэн зөв хөтөлдөггүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангахгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу цэцэрлэгийн эрхлэгч хариуцан үнэн зөв хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.4 Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар НДШ-ийн авлага 15.2 мянган төгрөг байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж авлага, өглөг үүсгэх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалт, 39 дүгээр зүйлийн 39.4.2 заалтуудыг мөрдөж өр, авлага үүсгэхгүй ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

- 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан
- 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

5 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| Балансын зүйл | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---------------|-----------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 45,987,225.96 | 49,742,126.71 |
| 27 | АВЛАГА | 1,419,565.63 | - |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 1,419,565.63 | - |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 44,567,660.33 | 49,742,126.71 |
| 61 | Түүхий эд материал | 1,442,222.00 | 1,442,222.00 |
| 62 | Тусгай зориулалттай материал | 1,442,222.00 | 1,442,222.00 |
| 66 | Хангамжийн материал | 43,125,438.33 | 48,299,904.71 |
| 67 | Бичиг хэргийн материал | 4,077,986.06 | 4,202,986.06 |
| 68 | Аж ахуйн материал | 33,825,853.42 | 34,951,153.42 |
| 70 | Түлш шатах тослох материал | 555,000.85 | 620,000.23 |
| 72 | Хүнсний материал | 4,408,356.00 | 8,525,765.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 258,242.00 | - |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 777,180,668.91 | 855,436,016.40 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 777,180,668.91 | 855,436,016.40 |
| 108 | Биет хөрөнгө | 717,910,668.91 | 795,856,016.44 |
| 109 | Барилга, байгууламж | 713,704,493.00 | 801,283,968.00 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | (7,378,525.66) | (29,832,005.62) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 39,802,774.00 | 44,820,580.00 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (32,759,527.31) | (33,611,522.12) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,558,810.00 | 15,507,573.00 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (11,830,428.42) | (12,252,330.12) |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 21,443,199.00 | 22,589,500.00 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | (18,630,125.70) | (12,649,746.70) |
| 126 | Биет бус хөрөнгө | 59,270,000.00 | 59,579,999.96 |
| 127 | Програм хангамж | 200,000.00 | 530,000.00 |
| 128 | Хасагдуулга | - | (20,000.04) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 59,070,000.00 | 59,070,000.00 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 823,167,894.87 | 905,178,143.11 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 99.96 | 419.30 |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 99.96 | 419.30 |
| 164 | Өглөг | 99.96 | 419.30 |
| 166 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 99.96 | 99.30 |
| 170 | Бусад өглөг | - | 320.00 |
| 171 | Байгууллагад төлөх өглөг | - | 320.00 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 823,167,794.91 | 905,177,723.81 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 823,167,794.91 | 905,177,723.81 |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 321,715,994.65 | 321,715,994.65 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 321,715,994.65 | 321,715,994.65 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 316,030,495.23 | 398,040,424.13 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 316,030,495.23 | 316,030,495.23 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | 82,009,928.90 |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 185,421,305.03 | 185,421,305.03 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 823,167,894.87 | 905,178,143.11 |

4.2. Аудитын хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| Үзүүлэлт | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|----------|---------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 444,922,067.32 | 529,214,075.00 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 53,145,267.32 | 99,152,475.00 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 53,145,267.32 | 99,152,475.00 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 53,145,267.32 | 99,152,475.00 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 53,145,267.32 | 99,152,475.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 391,776,800.00 | 430,061,600.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 391,776,800.00 | 315,166,900.00 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 391,776,800.00 | 315,166,900.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 114,894,700.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 114,894,700.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 426,784,690.15 | 447,204,146.10 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 426,784,690.15 | 447,204,146.10 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 414,615,640.96 | 442,067,303.42 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 172,852,072.65 | 209,932,383.21 |
| 151 | Цалин | 149,214,372.65 | 163,712,337.58 |
| 152 | Нэмэгдэл цалин | 7,855,700.00 | 26,741,145.63 |
| 154 | Урамшуулал | 15,782,000.00 | 19,478,900.00 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,818,439.03 | 28,150,929.74 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 14,373,469.10 | 19,772,572.71 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,501,255.15 | 1,901,037.08 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,578,525.85 | 2,085,515.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 311,702.00 | 453,481.99 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,053,486.93 | 3,938,322.96 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 117,702,557.00 | 114,049,057.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 6,545,973.00 | 4,356,048.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 94,510,684.00 | 94,486,609.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 16,645,900.00 | 15,206,400.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 11,031,263.11 | 3,868,079.90 |
| 171 | Бичиг хэргийн материал | 821,962.00 | 17,600.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 294,999.11 | 1,084,999.96 |
| 173 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 278,350.00 | 139,803.00 |
| 174 | Ном, хэвлэлийн зардал | 6,958.00 | 44,500.00 |
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 279,500.00 | 900,000.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 9,349,494.00 | 1,286,762.00 |
| 178 | Бараа материал акталсны зардал | - | 394,414.94 |
| 181 | Нормативт зардал | 60,003,381.00 | 54,986,291.00 |
| 182 | Эм | 98,900.00 | 98,800.00 |
| 183 | Хоол | 59,904,481.00 | 54,887,491.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 261,700.00 | 255,000.00 |
| 189 | Урсгал засвар | 261,700.00 | 255,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 256,000.00 | 595,600.00 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 256,000.00 | 595,600.00 |

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-----|-----------------------------------------------------------------------------|-------------------------|----------------------|
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 881,700.00 | 926,750.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 881,700.00 | 726,750.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | - | 200,000.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,808,528.17 | 29,303,212.57 |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,742,287.50 | 1,315,000.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,066,240.67 | 27,988,212.57 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,169,049.19 | 5,136,842.68 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 12,152,682.00 | 100,000.00 |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 12,152,682.00 | 100,000.00 |
| 237 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 5,036,842.68 |
| 240 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,036,842.68 |
| 242 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 16,367.19 | - |
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,367.19 | - |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 18,137,377.17 | 82,009,928.90 |
| 276 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 271,655,220.44 | - |
| 283 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 271,655,220.44 | - |
| 287 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | (271,655,220.44) | - |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | (253,517,843.27) | 82,009,928.90 |

4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-----|---------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 391,776,800.00 | 430,061,600.00 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 391,776,800.00 | 430,061,600.00 |
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 391,776,800.00 | 315,166,900.00 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 391,776,800.00 | 315,166,900.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 114,894,700.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 114,894,700.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 387,896,800.00 | 422,461,100.00 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 387,896,800.00 | 422,461,100.00 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 375,727,750.81 | 417,324,257.32 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 172,627,699.31 | 212,551,947.32 |
| 151 | Үндсэн цалин | 148,989,999.31 | 166,331,901.69 |
| 152 | Нэмэгдэл | 7,855,700.00 | 26,741,145.63 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 15,782,000.00 | 19,478,900.00 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,307,392.00 | 24,111,800.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 13,222,392.00 | 14,836,500.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,575,700.00 | 1,396,700.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,612,600.00 | 1,739,000.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 354,300.00 | 349,500.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,542,400.00 | 5,790,100.00 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 113,922,557.00 | 114,049,057.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 5,345,973.00 | 4,356,048.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 94,510,684.00 | 94,486,609.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 14,065,900.00 | 15,206,400.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 3,725,408.00 | 3,345,903.00 |
| 171 | Бичиг хэрэг | 100,000.00 | 67,600.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 850,000.00 | 1,150,000.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 278,350.00 | 139,803.00 |
| 174 | Ном, хэвлэл | 121,358.00 | 84,500.00 |
| 175 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 279,500.00 | 900,000.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,096,200.00 | 1,004,000.00 |
| 181 | Нормативт зардал | 60,394,265.00 | 59,738,700.00 |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,800.00 | 98,800.00 |
| 183 | Хоол, хүнс | 57,832,265.00 | 58,889,900.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,463,200.00 | 750,000.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,020,000.00 | 594,500.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | 820,000.00 | 339,500.00 |
| 189 | Урсгал засвар | 200,000.00 | 255,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 256,000.00 | 595,600.00 |

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-----|------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 192 | Дотоод албан томилолт | 256,000.00 | 595,600.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 899,430.00 | 986,750.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 899,430.00 | 786,750.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 200,000.00 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,574,999.50 | 1,350,000.00 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,574,999.50 | 1,350,000.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,169,049.19 | 5,136,842.68 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 12,152,682.00 | 100,000.00 |
| 232 | Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,152,682.00 | - |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 100,000.00 |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 16,367.19 | 5,036,842.68 |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,367.19 | 5,036,842.68 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 3,880,000.00 | 7,600,500.00 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 3,880,000.00 | 7,600,500.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,880,000.00 | 7,600,500.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 3,880,000.00 | 7,600,500.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,880,000.00 | 7,600,500.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (3,880,000.00) | (7,600,500.00) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|----|--------------------------------------------------|---------------------------------|-----------------------|-----------------------|----------------------------------------|
| 2 | 2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 262,645,994.65 | 185,421,305.03 | 562,380,706.68 | 1,010,448,006.36 |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 7,167,631.82 | 7,167,631.82 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 262,645,994.65 | 185,421,305.03 | 569,548,338.50 | 1,017,615,638.18 |
| 5 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | | | | |
| 6 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | | | | |
| 7 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 59,070,000.00 | | (253,517,843.27) | (194,447,843.27) |
| 9 | 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 321,715,994.65 | 185,421,305.03 | 316,030,495.23 | 823,167,794.91 |
| 10 | 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 321,715,994.65 | 185,421,305.03 | 316,030,495.23 | 823,167,794.91 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 321,715,994.65 | 185,421,305.03 | 316,030,495.23 | 823,167,794.91 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | 82,009,928.90 | 82,009,928.90 |
| 18 | 2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 321,715,994.65 | 185,421,305.03 | 398,040,424.13 | 905,177,723.81 |

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

| Зардлын зүйл | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|-----------------------------------------------------------|-----------------------|-----------------------|---------------------|---------------|
| 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 430,061,600.00 | 430,061,600.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 430,061,600.00 | 430,061,600.00 | - | 100.00 |
| Бараа, үйлчилгээний зардал | 429,961,600.00 | 424,924,757.32 | 5,036,842.68 | 98.83 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 213,905,900.00 | 212,551,947.32 | 1,353,952.68 | 99.37 |
| Үндсэн цалин | 160,584,500.00 | 166,331,901.69 | (5,747,401.69) | 103.58 |
| Нэмэгдэл | 32,160,500.00 | 26,741,145.63 | 5,419,354.37 | 83.15 |
| Урамшуулал | 21,160,900.00 | 19,478,900.00 | 1,682,000.00 | 92.05 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,066,300.00 | 24,111,800.00 | 2,954,500.00 | 89.08 |
| Тэтгэврийн даатгал | 25,323,400.00 | 14,836,500.00 | 10,486,900.00 | 58.59 |
| Тэтгэмжийн даатгал | 388,600.00 | 1,396,700.00 | (1,008,100.00) | 359.42 |
| ҮОМШӨ ний даатгал | 395,700.00 | 1,739,000.00 | (1,343,300.00) | 439.47 |
| Ажилгүйдлийн даатгал | 87,200.00 | 349,500.00 | (262,300.00) | 400.80 |
| Эрүүл мэндийн даатгал | 871,400.00 | 5,790,100.00 | (4,918,700.00) | 664.46 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 114,639,700.00 | 114,049,057.00 | 590,643.00 | 99.48 |
| Гэрэл цахилгаан | 5,346,000.00 | 4,356,048.00 | 989,952.00 | 81.48 |
| Түлш, халаалт | 94,087,300.00 | 94,486,609.00 | (399,309.00) | 100.42 |
| Цэвэр, бохир ус | 15,206,400.00 | 15,206,400.00 | - | 100.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 3,346,000.00 | 3,345,903.00 | 97.00 | 100.00 |
| Бичиг хэрэг | 100,000.00 | 67,600.00 | 32,400.00 | 67.60 |
| Тээвэр (шатахуун) | 1,150,000.00 | 1,150,000.00 | - | 100.00 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 66,000.00 | 139,803.00 | (73,803.00) | 211.82 |
| Ном, хэвлэл | 130,000.00 | 84,500.00 | 45,500.00 | 65.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 900,000.00 | 900,000.00 | - | 100.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 1,004,000.00 | (4,000.00) | 100.40 |
| Нормативт зардал | 59,738,700.00 | 59,738,700.00 | - | 100.00 |
| Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,800.00 | 98,800.00 | - | 100.00 |
| Хоол, хүнс | 58,889,900.00 | 58,889,900.00 | - | 100.00 |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 750,000.00 | 750,000.00 | - | 100.00 |
| Эд хогшил худалдан авах | 7,865,000.00 | 7,865,000.00 | - | 100.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 7,610,000.00 | 7,610,000.00 | - | 100.00 |
| Урсгал засвар | 255,000.00 | 255,000.00 | - | 100.00 |
| Томилолт, зочны зардал | 600,000.00 | 595,600.00 | 4,400.00 | 99.27 |
| Дотоод албан томилолт | 600,000.00 | 595,600.00 | 4,400.00 | 99.27 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 1,400,000.00 | 1,316,750.00 | 83,250.00 | 94.05 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,200,000.00 | 1,116,750.00 | 83,250.00 | 93.06 |
| Аудит, баталгаажуулалт | 200,000.00 | 200,000.00 | - | 100.00 |

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|-----|---------------------------------------------------------|-----------------------|-----------------------|-----------------------|-----------------|
| | зэрэглэл тогтоох зардал | | | | |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 | 1,350,000.00 | 50,000.00 | 96.43 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,400,000.00 | 1,350,000.00 | 50,000.00 | 96.43 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 100,000.00 | 5,136,842.68 | (5,036,842.68) | 5,136.84 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 100,000.00 | 100,000.00 | - | 100.00 |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 100,000.00 | 100,000.00 | - | 100.00 |
| 79 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 5,036,842.68 | (5,036,842.68) | - |
| 80 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,036,842.68 | (5,036,842.68) | - |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 430,061,600.00 | 430,061,600.00 | - | 100.00 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 315,166,900.00 | 315,166,900.00 | - | 100.00 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 315,166,900.00 | 315,166,900.00 | - | 100.00 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 114,894,700.00 | 114,894,700.00 | - | 100.00 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 114,894,700.00 | 114,894,700.00 | - | 100.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 22.00 | 22.00 | - | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 15.00 | - | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 6.00 | 6.00 | - | 100.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | - | - |